

8 ДУГААР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

Даалгаврын тоо-40

Хугацаа: 60 минут

САНАМЖ:

- Сонгох даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултыг сонгоно.
- Шалгалтын үргэлжлэх хугацаа 40 минут
- Задгай даалгавар тус бүр 1 оноотой.

“А” хувилбар

Сонгох даалгавар:

1. Хүмүүсийн ажиллаж, сурч, амьдарч буй аймаг, хот, сум, дүүрэг, баг, хорооны хүмүүс хоорондын харилцаа, нийгмийн бүлэг, байгууллагуудын хүрээггэнэ.
 - a. Орон нутгийн соёл
 - b. Орон нутгийн орчин
 - c. Орон нутгийн асуудал
 - d. Орон нутгийн үнэлгээ
 - e. Орон нутгийн түвшин
2. Хувь хүний хэрэгцээг таван шатлал болгон хуваан “ Сэдэл ба хувь хүн” хэмээх бүтээлдээ бичсэн Америкийн сэтгэл судлаач хэн бэ?
 - a. З.Фрейд
 - b. Э.Дюркгейм
 - c. А.Маслоу
 - d. Б.Спиноза
 - e. К.Оберг
3. нь тодорхой бүтэц зохион байгуулалт, эрх хэмжээ тогтоогүй түр зуурын шинжтэй бүлэг юм.
 - A.Бүлэг
 - B.Албан бус бүлэг
 - C.Албан бүлэг
4. Зөрчилдөөнийг ямар шалгуураар макро, микро гэж ангилсан вэ?
 - A. Шалтгаанаар нь
 - B. Хэлбэрээр нь
 - C. Цар хүрээгээр нь
 - D. Хугацаагаар нь
5. Стрессийг даван туулах аргад аль нь хамаарахгүй вэ?
 - A. Сайтар унтаж амрах
 - B. Биеийн тамираар хичээллэх
 - C. Цагийг хөгжилтэй өнгөрөөх
 - D. Дургүй зүйлээ хийх
6. Өөрийн амьдарч буй орон нутгийн хүн амын талаар мэдээлэл цуглуулахад тохирох аргуудыг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ?
 - A. Баримт материал цуглуулах арга
 - B. Түүврийн арга
 - C. Асуулгын арга
 - D. Лабораторийн арга
7. Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас Киллманы загварт холбогдох өгөгдлөөс буруу холбоосыг олно уу?
 - a. Сөргөлдөх- Бусдын санал бодлыг үл ойшоох, өөрийн зорилгыг урьтал болгох
 - b. Зайлсхийх- Зөрчилдөөний гадуур үлдэх, төвийг сахих
 - c. Буулт хийх- Өөрийн итгэл үнэмшил, байр сууринаас ухрах, татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх
 - d. Буулт хийх- аль аль талдаа таатай үр дүнд хүрэхийг эрмэлзэх
8. Зөрчилдөөний ангилалыг зөв харгалзуулна уу?

1	Зөрчилдөөнийг шалтгаанаар нь	a	Ширүүн, алгуур
2	Зөрчилдөөнийг хэлбэрээр нь	b	Богино, урт
3	Зөрчилдөөнийг цар хүрээгээр нь	c	Макро, микро
4	Зөрчилдөөнийг хугацаагаар нь	d	Ил, далд
5	Зөрчилдөөнийг эрчимээр нь	e	Материаллаг, оюун санааны

9. Хувь хүний соёл, бүлэг байгууллагын соёл, орон нутгийн соёл, улс үндэстний соёл, нийт хүн төрөлхтний соёл гэж ангилахдаа ямар шалгуурыг үндэслэн ангилсан байна вэ?
- a. Соёлын түвшингөөр нь b. Соёлын төлөв байдлаар нь
c. Соёлын бүтээгч, тээгчээр нь d. Соёлын илрэх хэлбэрээр нь
10. Оюуны соёлын жишээнд аль нь хамаарахгүй вэ?
- a. Шинжлэх ухаан, үлгэр домог b. Мэдлэг, зан заншил, урлаг
c. Шашин, баяр наадам, боловсрол d. Байшин барилга, хөшөө дурсгал
11. Зөв буруу, сайн муу гэж үнэлэгдэх ба сайшаах, урамшуулах, шийтгэх хөшүүрэгтэй хэм хэмжээ аль нь вэ?
- a. Зан заншил b. Ёс суртахуун c. Ёс заншил d. Зан үйл e. Зан суртахуун
12. Дараах хэм хэмжээний аль нь анхдагч хэмжээнд хамааралгүй вэ?
- a. Албан бус хэм хэмжээ b. Хууль, дүрэм c. Зан заншил
d. Ёс суртахуун e. Албан хэм хэмжээ
13. 1876 онд телефон, 1903 онд агаарын тээвэр, XX зуунд компьютерийг бүтээсэн нь дараах ойлголтуудын алинд хамаарах вэ?
- a. Соёлын нэвчилт b. Нээлт c. Соёлын харилцаа d. Соёлын өөрчлөлт
14. Соёлын зүйл нэг бүлгээс нөгөөд, нэг нийгмээс нөгөөд дэлгэрэх үйл явцыг юу гэдэг вэ?
- a. Соёлын нэвчилт b. Соёлын цочрол c. Соёлын хямрал d. Соёлын харилцаа e
15. Соёлын материаллаг талд хэт их ач холбогдол өгч, хэрэглэгээг шударга үнэн, хүнлэг сэтгэлээс эрхэмд үзэх явдал даамжирснаас болж нийгэмд үүсдэг сөрөг үр дагаврыг соёл судлалд хэрхэн нэрлэдэг вэ?
- a. Соёлын гажилт b. Соёлын хожимдолт c. Соёлын зөрчилдөөн
d. Харийн соёлын ноёрхол
16. Эдийн соёлын жишээг зөв илэрхийлсэн мөрийг олно уу?

a	Зан заншил	Сүхбаатарын талбай	Хөгжим	Мэдлэг
b	Зүйр үгс	Жүжиг	Шинжлэх ухаан	Шашин
c	Ном	Машин техник	Тоглоомын талбай	Гар утас
d	Мэдлэг	Уртын дуу	Уран зураг	Үлгэр домог
e	Хөгжим	Жүжиг	Уртын дуу	Мэдлэг

17. Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Төрийн байгууллага	a	Улсын бүртгэлд бүртгэгдсэн тэдний гол зорилго нь ашиг олоход оршино.
2	Төрийн бус байгууллага	b	Өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр нэгдсэн, төрөөс хараат бус ашгийн төлөө байгууллага
3	Аж ахуйн нэгж	c	Төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүргэж байдаг, төсвөөс санхүүждэг байгууллага

18. Хүний хэрэгцээг хангах зорилгоор үйлдвэрлэлийн нөөцийг ашиглан бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргаж байгаа хүмүүсийн зорилго чиглэлтэй ухамсартай үйл ажиллагааг гэнэ.

- a. Хөдөлмөр b. Зах зээл c. Үйлдвэрлэл d. Өрсөлдөөн e. Солилцоо

19. Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзлэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг гэнэ.

- a. Зах зээл b. Эрэлт c. Нийлүүлэлт d. Эквивалент бараа




20. Машин, тоног төхөөрөмж, барилга, зам гүүр, түүхий эд, материал, эд хогшил, мөнгө зэргийг үйлдвэрлэлийн аль нөөцөд багтаан ойлгох вэ?

- a. Газар b. Хөдөлмөр c. Капитал d. Үйлдвэрлэл эрхлэх ур чадвар

21. Дараах өгөгдлүүдийн аль нь худал вэ?

- a. Эрэлт их бол барааны хомсдол үүснэ.
b. Нийлүүлэлт их бол барааны илүүдэл үүснэ.
c. Нийлүүлэлт бага бол хомсдол үүснэ.
d. Эрэлт бага бол хомсдол бий болно.

22. Аж ахуйн нэгжийн хэлбэрийг зөв илэрхийлсэн зурагтай холбоно уу?

1. Үйлдвэрлэл	2. Үйлчилгээ	3. Худалдаа
		
a.	b.	c.

- a. 1c 2a 3b b. 1a 2c 3b c. 1c 2b 3a d. 1b 2a 3c e. 1a 2b 3c

23. Газар, капитал, хөдөлмөр болон хүний ур чадвар нь эдийн засгийн аль ойлголтод хамаарах вэ?

- A. Зах зээлийн нөөц B. Эдийн засгийг эрэлт хэрэгцээг бүрдүүлэх хүчин зүйлсэд
C. Үйлдвэрлэлийн нөөцөд

24. Цэгийн оронд тохирох ойлголтыг сонгоно уу. Хүний хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөц баялгаар хангахыг гэнэ.

- A. орон нутгийн эдийн засаг b. эдийн засаг c. зах зээл D. үйлдвэрлэл

25. Нийгэм, орон нутгийн болон хүмүүс хоорондын харилцааг зохицуулах гол хэм хэмжээ бөгөөд гол зорилго нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдал юм. Энд ямар баримт бичгийн тухай өгүүлсэн байна вэ?

- a. Конвенц b. Тунхаглал c. Пакт d. Хууль

26. 1948 оны 12 сарын 10-нд ямар үйл явдал болсон бэ?

- a. Англид Магна Харти гэрээ батлагдсан
 b. Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсан
 c. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан
 d. АНУ-д анхны Үндсэн хууль батлагдсан
 e. Дэлхийн анхны улс төрийн нам байгуулагдсан

27. Хүний эрхийн зарчмуудад аль нь хамааралгүй вэ?

- a. Хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчим b. Тэгш байх зарчим
 c. Харилцан хамааралтай байх зарчим d. Холбоотой байх зарчим

28. Хүмүүс төрөлхийн болон төрөлхийн бус шинжээрээ хоорондоо ялгаатай байгааг гэнэ.

- a. Нийгмийн давхраа b. Нийгмийн ялгарал c. Нийгмийн давхраажилт
 d. Нийгмийн шинж e. Нийгмийн тэгш бус байдал

29. Дараах өгөгдлөөс аль нь төрөлхийн ялгаралд хамаарах вэ?

- a. Нэр хүнд, боловсрол b. Нас, хүйс, үндэс угсаа
 c. Ажлын туршлага, орлого d. Мэдлэг, ажил мэргэжил

30. Хүний эрх нь хүн бүрд төрж мэндлэхэд нь хамт заяадаг төрөлх чанар тул хүн бүр:

- a. Үүрэг хүлээгч b. Эрх эдлэгч c. Бусдын эрхийг хүндэтгэгч
 d. Бусдын эрхийг хамгаалагч

31. 1215 онд Английн хаан Жон “Магна харта” хэмээх бичиг баримтад гарын үсэг зурсныг хүний эрхийн түүхэн баримт бичгүүдийн нэг гэж үздэг. Энэ нь дараах баримт бичгийн аль нь вэ?

- A. Зөвшилцлийн гэрээ C. Тусгаар тогтнолын тунхаглал
 B. Хаммураби хааны хууль D. Күнзийн сургаал

32. Зөв харгалзуулаарай.

1	Хүний эрхийн зарчмууд	A	Хүний эрх, эрх чөлөөг хүндлэх, шударга байх, өөртөө итгэх
2	Хүний эрхэм зэргийг хүндэтгэх	B	Хүн эрхтэйгээ төрдөг, түүнийг хэн нэгнээс аваагүй, харин түүнийгээ заавал эдлэх ёстой.
3	Үүрэг хариуцлага хүлээх	C	Хүмүүний төрлийг олж төрөх нь зүүний үзүүрт ширхэг нэгэн арвай будаа тогтохтой адил чухал нэгэн хувь заяа
4	Тэгш эрх	D	Хүний эрхэм зэргийг хүндэтгэх, үүрэг хариуцлага хүлээх, харилцан хамааралтай байх, тэгш байх

5	Үнэт зүйл	Е	Үндэс угсаа, хэл соёл, шашин шүтлэг, нас хүйс, нийгмийн гарлаар ялгаварлахгүй
---	-----------	---	---

33. Хүн бүр эрхээ эдлэх эрх зүй, эдийн засаг, нийгмийн нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээ авах нь төрийн хүний эрхийг хамгаалах..... үүрэг юм.
- a. Хүндэтгэх b. Хангах c. Хамгаалах d. Ахиц дэвшил гаргах
34. Хүний эрхийн талаар олсон ололт амжилтаа бататгаж, ахиулах нь төрийн хүний эрхийг хамгаалах..... үүрэг юм.
- a. Хүндэтгэх b. Хангах c. Хамгаалах d. Ахиц дэвшил гаргах
35. Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Конвенц	a	Ямарваа нэгэн асуудлаар улс орнуудыг тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг уриалсан олон улсын баримт бичиг
2	Пакт	b	Хүний эрхийн асуудлаар улс орнуудад үүрэг хүлээлгэдэг олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг төрөл
3	Тунхаглал	c	Тодорхой асуудлыг хэлэлцэн тохирч баталсан олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг төрөл

36. Баг, хорооны нутгийн өөрөө удирдах байгууллага аль нь вэ?
- a. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал b. Яам c. Иргэдийн Нийтийн хурал
d. Хэрэгжүүлэгч агентлаг e. Тохируулагч агентлаг
37. Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгж нь аль вэ?
- A. баг, хороо B. сум, дүүрэг C. аймаг D. нийслэл
38. ИНХ, ИТХ-ын тэргүүлэгчдээс гарч буй шийдвэрийг хэрхэн нэрлэдэг вэ?
- A. зарлиг B. захирамж C. тушаал D. тогтоол
39. Тухайн орон нутагт хүүхдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд насанд хүрэгчдэд нөлөөлж, хамтран ажилладаг сонгуульт байгууллагыг нэрлэнэ үү.
- A. Хүүхдийн нэгдсэн зөвлөл C. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
B. Сургууль D. НҮБ
40. Орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцыг зөв дараалалд оруулсныг сонгоорой.

Өгөгдөл: /1-Санаачлах, 2-Хэрэгжүүлэх, 3-Боловсруулах, 4-Хэлэлцэх, 5-Батлах, 6-Үнэлгээ хийх/

- A. 1, 3, 5, 4, 2, 6 C. 1, 3, 4, 5, 2, 6
B. 1, 3, 5, 4, 2, 6 D. 1, 4, 3, 5, 2, 6

8 ДУГААР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

Даалгаврын тоо-40

Хугацаа: 60 минут

САНАМЖ:

- Сонгох даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултыг сонгоно.
- Шалгалтын үргэлжлэх хугацаа 40 минут
- Задгай даалгавар тус бүр 1 оноотой.

“В” хувилбар

1. Өөрийн хүсэл эрмэлзлээр үнэ хөлсгүйгээр орон нутаг нийгмийнхээ төлөө хийж байгаа үйл ажиллагааггэнэ.

- a. Хандивын аян b. Тусламжийн үйлс c. Сайн дурын үйл ажиллагаа
d. Хамтын үйл ажиллагаа e. Нийгмийн албан оролцоо

2. Хувь хүмүүс, өрх гэрүүд хоршин амьдрахыг шалтгааныг “ механик эв нэгдэл”, “ органик эв нэгдэл” гэсэн ойлголтоор тайлбарласан эрдэмтэн хэн бэ?

- a. З.Фрейд b. Э.Дюркгейм c. А.Маслоу d. Б.Спиноза e. К.Оберг

3. Хэрэгцээний ангилалыг зөв харгалзуулна уу?

- | | |
|--------------------------------|--|
| 1 Бие физиологийн хэрэгцээ | a Бүтээл туурвих |
| 2 Аюулгүй байдлын хэрэгцээ | b Амжилт, шагнал, байр суурь |
| 3 Нийгмийн хэрэгцээ | c Гэр бүл, хайр, найз нөхөд, ажил мэргэжил |
| 4 Хүндлэл хүлээх хэрэгцээ | d Хууль журам, хамгаалалт |
| 5 Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ | e Унтаж амрах, хоол хүнс, орон байр |

4. Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас Киллманы загварт холбогдох өгөгдлөөс буруу холбоосыг олно уу?

- a. Сөргөлдөх- Харилцан тохиролцох b. Зайлсхийх- Үгүйсгэх арга
c. Буулт хийх- Найр тавих d. Хамтран ажиллах-Зэрэгцэн орших

5. Хүндлэл хүлээх хэрэгцээнээс аль нь илүүц вэ?

- A. амжилт B. байр суурь C. хариуцлага D. ажил

6. Хүмүүс өөртөө байхгүй зүйлийг бусдаас авах, солилцоо хийх замаар бусадтай харилцдаг гэж үзсэн. Үүнийг ямар нэр томъёогоор тайлбарласан бэ?

- A. Механик эв нэгдэл B. Хэрэгцээний онол C. Органик нэгдэл D. Томас-Киллманы загвар

7. Зөрчилдөөний ангиллуудын өгөгдлүүдийг дараах хүснэгтэд зөв байршуулсныг сонгоорой.

Өгөгдөл: /1-материаллаг, 2-оюун санааны, 3-нийгмийн, 4-ширүүн, 5-алгуур/

Шалтгаан а.....

Эрчим б.....

A. a-1,2,3; b-4,5 B. a-4,5; b-1,2,3 C. a-1,2; b-3,4,5 D. a-3,4,5; b-1,2

8. Хэрэгцээний ангилалыг зөв харгалзуулна уу?

1	Бие физиологийн хэрэгцээ	a	Бүтээл туурвих
2	Аюулгүй байдлын хэрэгцээ	b	Амжилт, шагнал, байр суурь
3	Нийгмийн хэрэгцээ	c	Гэр бүл, хайр, найз нөхөд, ажил мэргэжил
4	Хүндлэл хүлээх хэрэгцээ	d	Хууль журам, хамгаалалт
5	Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ	e	Унтаж амрах, хоол хүнс, орон байр

9. Соёлыг биет (материаллаг) ба биет бус (оюуны) соёл гэж ангилахдаа ямар шалгуурыг үндэслэн ангилсан байна вэ?

a. Соёлын түвшингөөр нь b. Соёлын төлөв байдлаар нь c. Соёлын бүтээгч, тээгчээр нь
d. Соёлын илрэх хэлбэрээр нь

10. Эдийн соёлын жишээнд аль нь хамаарах вэ?

a. Шинжлэх ухаан, үлгэр домог b. Мэдлэг, зан заншил, урлаг
c. Шашин, баяр наадам, боловсрол d. Байшин барилга, хөшөө дурсгал

11. Өдөр тутмын аж төрөхүйд баримталдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил, уламжлал зэргийг..... гэнэ.

a. Албан хэм хэмжээ b. Ёс суртахуун c. Хэм хэмжээ d. Албан бус хэм хэмжээ

12. Аль хэм хэмжээ нь буруу, зөв гэж хатуу үнэлэгддэггүй вэ?

a. Албан бус хэм хэмжээ b. Хууль, дүрэм c. Зан заншил d. Ёс суртахуун


13. Соёлын өөрчлөлтөнд нөлөөлөх хүчин зүйлсэд аль нь хамаарахгүй вэ?

a. Шинэ бүтээл, ололт амжилт b. Байгаль орчин c. Соёлуудын харилцан нөлөөлөл, нэвчилт d. Харийн соёлын ноёрхол

14. Соёлын харилцан нөлөөлөл, нэвчилтийн жишээг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ?

a. Төрсөн өдрийн баяр b. Сүм хийд c. Кирилл бичиг d. Эрийн гурван наадам

15. Аль нь зөв зураглал вэ?



16. Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Хэл ярианы соёл	a	Хүний танин мэдэх үйл ажиллагааны үр дүн
2	Бэлгэдэл	b	Юмс үзэгдлийн тодорхой шинж чанарыг илэрхийлсэн дүр, дүрслэл
3	Мэдлэг	c	Хувь хүний боловсрол, хүмүүжил, ёс суртахууны

17. Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Орон нутгийн соёл	a	Газар зүйн байршил төдийгүй эрх мэдэл, түүний хүрээ хязгаар
2	Орон нутгийн эдийн засаг	b	Орон нутгийн хүн амын ажил эрхлэлт, зах зээлийн харилцаа, орон нутгийн орлоготой холбоотой багц асуудлыг багтаана
3	Орон нутаг	c	Тухайн нутгийн зон олны хөгжлийн үндэс болж буй эрт эдүгээд эрхэмлэсээр ирсэн, хойч үедээ өвлүүлэн үлдээх хүсэлтэй бүхий л үнэт зүйлс

18. Худалдан авагчийн хүсэл сонирхлын үндсэн дээр тодорхой үнээр худалдан авах боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг гэнэ.

- a. Зах зээл b. Эрэлт c. Нийлүүлэлт d. Эквивалент бараа

19. Худалдан авагчид буюу хэрэглэгчид, тэдэнд бараагаа борлуулж ашиг олох сонирхолтой худалдагчид буюу үйлдвэрлэгчдийн хоорондын харилцан үйлчлэлийг гэнэ.

- a. Хөдөлмөр b. Зах зээл c. Үйлдвэрлэл d. Өрсөлдөөн e. Солилцоо

20. Хүний оюуны ба биеийн хүчний чадавхийг үйлдвэрлэлийн аль нөөцөд багтаан ойлгох вэ?

28. Хүнийг арьс өнгө, нас хүйс, хэл, шашин шүтлэг зэргээр нь үндэслэн алагчлах буюу хязгаарлахыг..... гэнэ.

a. Ялгаварлан гадуурхалт b. Үл ялгаварлан гадуурхалт c. Нийгмийн ялгарал d. Түр, тусгай арга хэмжээ e. Хүний эрхийг хангах түр тусгай арга хэмжээ

29. Дараах өгөгдлөөс аль нь төрөлхийн бус ялгаралд хамаарахгүй вэ?

a. Нэр хүнд, боловсрол b. Нас, хүйс, үндэс угсаа c. Ажлын туршлага, орлого d. Мэдлэг, ажил мэргэжил e. Улс төр, эдийн засгийн байр суурь

30. 2015 онд дэлхийн эрэлттэй 10 мэргэжлийг тодорхойлжээ. Аль нь хамаарахгүй вэ?

a. Түүхч, нягтлан бодогч b. Программын инженер, хуульч c. Математикч, биологич d. Даатгалын шинжээч, статистикч e. Дээрх бүгд хамаарна.

31. Хүний эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх, бусдын эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэгч тул төр нь:

a. Үүрэг хүлээгч b. Эрх эдлэгч c. Бусдын эрхийг хүндэтгэгч d. Бусдын эрхийг хамгаалагч

e. Сонголтот төр

32.

33. Төр нь хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд тодорхой байгууллага, тогтолцоог бүрдүүлэн ажилладаг. Үүнийг..... гэнэ.

a. Хүний эрхийг хамгаалах олон улсын байгууллага

b. Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо

c. Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо

d. Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага

e. Дээрх бүгд хамаарна.

34. Бусад хүн, байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх нь төрийн хүний эрхийг хамгаалах..... үүрэг юм.

a. Хүндэтгэх b. Хангах c. Хамгаалах d. Ахиц дэвшил гаргах e. Боломж олгох

35. Өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Иргэн	a	Тухайн улсын хуулийн дагуу иргэдийн биелүүлбэл зохих шаардлагууд
2	Иргэний эрх	b	Тухайн улс орны хууль ёсны харьяалал бүхий хүн
3	Иргэний үүрэг	c	Тухайн улсын хуулиар иргэддээ тогтоож өгсөн эрх, эрх чөлөө

36. Хүн бүр эрхээ эдлэхэд саад учруулахгүй байх төрийн зүгээс ялгаварлан гадуурхахгүй нь төрийн хүний эрхийг хамгаалах..... үүрэг юм.

a. Хүндэтгэх b. Хангах c. Хамгаалах d. Ахиц дэвшил гаргах e. Боломж олгох

37. Аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага аль нь вэ?

- a. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал b. Яам c. Иргэдийн Нийтийн хурал d. Хэрэгжүүлэгч агентлаг
e. Тохируулагч агентлаг

38. Тодорхой нутаг дэвсгэрт аж төрөн суугаа хүмүүс, тэдний төлөөлөл өөрсдийн амьдрал аж ахуйд хамаатай бүхий л асуудлыг орон нутгийнхаа санхүү эдийн засгийн боломждоо тулгуурлан хууль тогтоомжийн хүрээнд хамтран шийдвэрлэх эрх мэдлийг гэнэ.

A. Орон нутгийн удирдлага C. Нутгийн өөрөө удирдах ёс

B. Шийдвэр гаргах үйл явц D. Иргэдийн Нийтийн Хурал

39. Баг, хорооны Иргэдийн нийтийн Хурлын эдлэх эрх аль нь вэ?

A. Баг, хорооны Засаг даргыг сонгох, ажлаас чөлөөлөх

B. Сум, дүүрэг, аймаг, нийслэлийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

C. Засаг даргыг томилох, ажлаас чөлөөлөх

D. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийг хэлэлцэн батлах зэрэг эрх үүргийг хэрэгжүүлдэг.

40. Орон нутагт бодлого шийдвэр гаргах үйл явцыг зөв дараалалд оруулсныг сонгоорой.

Өгөгдөл: /1-Санаачлах, 2-Хэрэгжүүлэх, 3-Боловсруулах, 4-Хэлэлцэх, 5-Батлах, 6-Үнэлгээ хийх/

A. 1, 3, 5, 4, 2, 6

C. 1, 3, 4, 5, 2, 6

B. 1, 3, 5, 4, 2, 6

D. 1, 4, 3, 5, 2, 6